

### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Нийлүүлэх бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

**Барааны нэр:** Улсын аварга малчин, хошой аварга малчинд олгох цом

№	Барааны техникийн үзүүлэлт	Барааны техникийн тодорхойлолтын үзүүлэлт, шаардлага	Санал болгож буй тодорхойлолт
1.	1.1. Цомд тавигдах ерөнхий шаардлага:	30 см өндөртэй, 32 см өргөнтэй, елзий болон цэцгэн хээгээр чимэглэсэн ширээ хэлбэрийн суурьтай, бадамлянхуа цэцгэн тавцантай, их биеийн дээд хэсэгт алтан соёмбо, төв хэсэг дэх дугуй дүрсний дээд хэсэгт чандмань 2 талаараа тариан түрүүтэй, 5 хошуу малын дүрс байршуулсан, доод хэсэгт нь улсын аварга малчин гэж бичсэн 145, хошой аварга малчин гэж бичсэн 8, тухайн оныг товойлгож бичсэн, их биеийн ар талыг түмэн насан хээгээр чимэглэж "Монгол улсын Засгийн газраас дурсгав" гэж бичсэн байна.	
	1.2. Гарал үүсэл:	Монгол Улс.	
	1.3. Үйлдвэрлэгчийн нэр, байршлын хаяг	Үйлдвэрлэгчийн нэр, байршлын хаягийг тодорхой бичиж ирүүлнэ.	
	1.4. Үйлдвэрлэсэн он	2024 он.	
	1.5. Материал, хэмжээ, орц	- Цомны чулуутай нийт өндөр-300мм, өргөн-160мм, урт-320мм, - Их бие нийт өндөр 280мм, \чулуугүй\ - Суурь хэсэг: өргөн-130мм, өндөр-50мм, урт-290мм, \чулуугүй\ - Их биеийн дээд хэсэг: өргөн-240мм, өндөр-230мм, зузаан суурь хэсгээр-14мм, оройн хэсгээр-7мм, - Логоний хэсэг-120мм диаметр. Чулуун суурь: өргөн-160мм, урт-320мм, зузаан-18мм Цомны үндсэн суурь хэсэг нь доод чулуун суурьтай бүрэн холбогдоно.	
	1.6. Савлалт, хадгалалт, хэрэглээ	Тээвэрлэлтийн явцад эвдэрч гэмтэхээргүй байх ба тус бүрийг арьсан цүнхэнд савласан байна. Савлах цүнхны зураг, эсвэл загвар ирүүлэх	
	1.7. Бараа хүргэх газар:	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам. Захиалагч нэг бүрчлэн үзэж, тоолж шалган хүлээж авна.	
	1.8. Ачаа тээвэрлэх нөхцөл:	Барааг гүйцэтгэгч өөрийн тээврээр тээвэрлэж хүргэж ирнэ. Тээвэрлэлтийн үед байгаль, цаг агаарын нөхцөл байдлыг харгалзан үзэж, алдагдах, гэмтэхээс урьдчилан сэргийлнэ.	
	1.9. Эх бэлтгэх:	Гүйцэтгэгч цомны хэмжээ загвар хийцийн шаардлага хангасан зураг, бүдүүвч хавсаргах.	

